



Математик интерактив дасгал 3

Амжилт хүсье





Зөв хариултыг сонгоорой




1. Хоёр тооны ялгавар 38.7 байв. Нэгдүгээр тооны бүхлийн цэгийг 1 оронгоор хойшлуулбал хоёрдугаар тоо нь үүснэ. Нэгдүгээр тоог олоорой.

A. 3.87 B. 4.3 C. 387 D. 430


2. Хоёр тооны ялгавар 48.6 байв. Хоёрдугаар тооны бүхлийн цэгийг 1 оронгоор хойшлуулбал нэгдүгээр тоо нь үүснэ. Нэгдүгээр тоог олоорой.

A. 5.4 B. 54 C. 486 D. 540





3. Тоон шулуун дээр байгаа М цэгт харгалзах тоог олоорой.






A. 5

B. 1 бүхэл $1/2$

C. $1/5$

D. $1/2$





4. Тоон шулуун дээр байгаа А цэгт харгалзах тоог олоорой.







A. 3

B. 1 бүхэл $\frac{1}{3}$

C. $\frac{1}{3}$

D. $\frac{3}{10}$






5.78.054 бутархайг аравны хэсгээр тоймлоорой.

A. 78.05 B. 78 C. 78.1 D. 78.2

6. "Дөрвөн бүхэл тавны гурав" гэсэн тоог энгийн бутархай хэлбэрээр бичээрэй

A. 4 бүхэл $5/3$ B. 4 бүхэл $3/5$

C. 3 бүхэл $4/5$ D. 5 бүхэл $3/4$





7. **3.058** бутархайг энгийн бутархай хэлбэртэй бичсэнийг олоорой.

A. 3 бүхэл $58 / 100$ B. 3 бүхэл $58 / 10$

C. 3 бүхэл $58 / 1000$ D. 3 бүхэл $58 / 10000$


8. Хоёр онгоц нийлээд 3500 т ачаа зөөжээ. Нэг онгоц нөгөөгөөс 1.5 дахин их ачаа зөөсөн байлаа. Онгоц бүр хичнээн тонн ачаа зөөсөн бэ?

A. 1400т ба 2100т

B. 1000 т ба 2500 т

C. 2333.3т ба 1166.7 т

D. 1750 т ба 1750 т





9. 2.0603 бутархайг хэрхэн унших вэ?

A. 2 бүхэл мянганы 603 B. 2 бүхэл зууны 603

C. 2 бүхэл арван мянганы 603

D. 2 бүхэл 603

10. Аль нь хамгийн ихээс хамгийн бага руу эрэмбэлэгдсэн байна вэ?

A. 1.235 ; 1.253 ; 2.235 ; 2.253 B. 1.253; 1.235; 2.253; 2.235

C. 2.253; 2.235; 1.235; 1.253 D. 2.253 ; 2.235; 1.253; 1.235

Баярлалаа

